



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1962-8- 2

Дугаар. 182

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн үйлдэхүүнийг ханган
нийлүүлэх трестийн дүрмийг батлах
тухай.

73-ийн 1990-ны 140-р тогтоолоор хүчингүй.

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн
хуралдаанаас ТОГТООХ НЬ:

I. Улаанбаатар хотын хөдөө аж ахуйн үйлдэхүүнийг
ханган нийлүүлэх трестийн дүрмийг баталсугай.



Лувсанчоймбол

ЛУВСАНЧОЙМБОЛ

Балжинням

БАЛЖИННЯМ

Хянаж зөвшөөрсөн
Боловруулж нийлсэн
Санал оруулсан
цо. Чу.

УБ хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн
1962 оны 8-р сарын 2-ны өдрийн. . . р журлаар батлав.

Улаанбаатар хотын хөдөө аж ахуйн
үйлдэхүүнийг ханган нийлүүлэх
трестийн дүрэм.

НЭГ. Хөдөө аж ахуйн үйлдэхүүнийг ханган нийлүүлэх трест
нь Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны харьяа Улаан-
баатар хотын худалдаа удирдах газрын шууд удирдлагын дор ажил-
лана.

ХОЁР. Х.А.А.У.Х.Н. трест нь биеэ даасан аж ахуйн тосгоо
бүхий, баланстай, банкинд тусгай харилцах данстай аж ахуйн бай-
гууллага болох бөгөөд хууль ёсоор зохих ажлаа эрхлэн гүйцэтгэх
эрхтэй.

ГУРАВ. Х.А.А.У.Х.Н. Трест нь БНМА Улсын дотор дагаж мөр-
дож буй хууль дүрмийн дагуу улсаас тогтоосон үүрэг дээдсаврийн
төлөвлөгөөг биелүүлэх үүрэгтэй ба үүнтэй холбогдсон эд хөрөн-
гийг бүрэн эзэмшин хариуцна.

ДӨРӨВ. ХААҮХН трест нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
хуулиар тогтоогдсон зохих тамга, тэмдэг ба бичгийн нүүртэй байх
бөгөөд тухаал, протоколуудыг гаргана.

ТАВ. ХААҮХН Трест нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг
бэлтгэх тээвэрлэх, хадгалах, нийлүүлэх ажилд зохих шаардлага
журианд тоо хэмжээ чанар үзэмж бүрэн тохирсон өөрийн мэдлийн
аж ахуйн хөрөнгө, дулаан сэрүүн өмчлөх, зойр, орон сууц, албан
хэрэг зориулагдсан барилга төхөөрөмж төлөг хэрэгсэлтэй байхыг
дээр авто тээвэр ба эрдийн хэсгийн ашиглалтыг зохион байгуулж
тээврийн хэсгийн даац ба гүйлт ашиглалтыг сайжруулах хяналт
тавьж байна.

ЗУРГАА. ХААҮХН Трест нь дор дурьдсан үүргүүдийг биелүүлэх үүнд:

а/Сангийн аж ахуйг удирдах газрын харъяа сангийн аж ахуйнуудаас нийслэл хотын хөдөлмөрчдийн хэрэгцээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг улсын төлөвлөгөө хувиар ёсоор хүлээн авч УБ хотын худалдаа, нийтийн хоолны газрын хэрэгцээг ханган нийлүүлж байна.

б/Мах ба сүүний комбинат, үйлдвэрлэл хөрлооллын артезиануудаас улсын төлөвлөгөөт захиалга ёсоор аж ахуйн гэрээ байгуулж уг үйлдэхүүнийг худалдаа нийтийн хоолны газрын жинхэнэ хэрэгцээ захиалгыг баримтлан үйлдвэрээс өөрийн складаар дамжуулах ба дамжуулахгүйгээр шууд хэрэглэгч байгууллагуудад хүргэх эх үүрэгтэй.

в/Хотын хөдөлмөрчдийн хэрэгцээг хангалзан хөдөө аж ахуйн нэгдлүүдээс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг улсын тогтоосон журмаар аж ахуйн гэрээ байгуулж худалдаа нийтийн хоолны газруудад хувцарлан олгоно. Байгуулсан гэрээний биелэлтийг улирал дутам шалгах дүгнэж байна.

г/Өөрийн склад, зойр, агуулах газрын бараа материалын ерөлт хураалт хадгалалтыг зохиох журмаар гүйцэтгэж гэмтлээс хамгаална.

д/Үйлдвэр, базуудад хүлээн авах барааны хувиар төлөвлөгөөг хатуу баримтлан аж ахуйн гэрээ ёсоор тоо хэмжээ яв чварын шалган авч татан аваад хувиарлан олгоно.

с/Бараа материалын татан авалт ба хувиарлан олгоогийн бүртгэл мэдээг цаг хугацаанд нь тогтоосон маягт баард ёсоор үнэн зөв гаргаж байна.

ДОЛОО.Захиргаа болон ажиллагааны зардлыг батлагдсан төсөвт захирагдан үр ашигтай зарцуулж, аж ахуйн тооцоот бэхжүүлэн, арвилан хэмнэх зарчмыг баримтлана.

ХААҮХН Трест нь өөрийн ажил явцллагыг бицлүүлэн гүйцэтгэхдээ БНМАУ-ын дотор дагаж мөрдөж буй хууль ёсоор дөр заасан эрхийг эдлэнэ. Үүнд:

1. Өөрийн үүргийг биелүүлэхийн тул улсын үйлдвэр, аж ахуйн газар сангийн аж ахуй нэгдлүүд болон хүмүүстэй гэрээ хэлэлцээ байгуулах, улсын банкнаас мөнгөн зээл авах, харилцах данс нээх, худалдаа нийтийн хоолны газруудтай бараа материалын үнийн тооцоо хийх, албан байгууллага болон хүмүүсийн эрэлт хүсэлт зөвлөлгөөнийг хүлээн авч шийдвэрлэж байх.

Улсын арбитрын газар ба хуулийн байгууллаарат хүсэлт тавих, хэрэг нэхэмжлэх зэргээр харилцах эрхтэй болно.

2. Үедээ аж ахуйн үйлдэхүүнийг ханган нийлүүлэх явдалд холбогдсон туслах чанарын салбар үйлдвэрийн газрыг байгуулаж ажиллуулах.

3. Орон барилга, тээврийн хэрэгсэл, эд хогшлыг ажиллагаа нна шаардлаганд уялдуудан худалдах, худалдан авч олж бэлтгэх,

түрээслэн авах, түрээслэх ажлыг эрхлэнэ.

НАЙМ. ХААҮХН Трест нь Улаанбаатар хотод орших бөгөөд түүний дүрмийн фондын таван сая төгрөгөөр тогтооно.

УДИРДАМЖ.

ЕС. ХААҮХН Трестийн ажил явуулгыг трестийн дарга, түүний орлогчдоос эрхлэн удирдаж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Трестийн хэлтэс тасгийн хариуцах ажил хувиарыг тогтоож батлана.

2. ХААҮХН Трест нь трестийн дарга орлогч нарын удирдлаганд дор гурьдсан хэлтэс тасаг ангиудтай байна. Үүнд:

НЭГ. ХААҮХН Трестийн захиргааны

- а/Санхүүгийн хэлтэс
- б/Төлөвлөгөө, тоо бүртгэлийн хэлтэс
- в/Материал хангамжийн хэлтэс
- г/Боловсон хүчний тасаг.

ХОЁР. Худалдаа бэлтгэлийн.

- а/Аймаг дундын төлөөлөгчид
- б/Мех ба машин бүтээгдэхүүний анги
- в/Сүү ба сүүн үйлдэхүүний анги
- г/Хүнсний ногооны анги
- д/Дахин боловсруулах үйлдвэр
- е/Барилга бариаа боодлын тасаг
- з/Хүнсний бүтцийн шинжилгээний лаборатор
- ж/Аж ахуйн тосгоотой авто хөдлийн, граж

ТАЙЛАН.

АРАВ. ХААҮХН Трест нь аж ахуйн өмж явуулах жилийн

хугацааг энэ бүрийн календарыноны I-р сарын I-нээс
I2-р сарын 3I-ний өдрийг дуустал тооцно.

АРВАН НЭГ. ХААҮХН Трестийн санхүүгийн тайлан бэлэнсөмт
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Худалдаа Бэлтгэлийн Яамны
системд тогтоосон журмын ёсоор үйлдэж гаргах болно.

ХААҮХН Трестийн цэвэр ашгийг БНМАУ-ын дотор дагаж
мөрдөж буй хууль дүрмэнд зохицуулан гүйцэтгэх байна.

Трестийг байгуулах ба татан буулгах тухай.

Улаанбаатар хотын хөдөө аж ахуйн үйлдэхүүнийг ханган
нийлүүлэх трестийг байгуулах ба татан буулгах асуудлыг гарц-
хүү дээд байгууллагын шийдвэрээр гүйцэтгэх.

1962-8-2.

Улаанбаатар хот.